

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЯВЦЫН ХЯНАЛТ  
ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ИЛТГЭХ ХУУДАС

2023 оны 06 сарын 13

Мандалговь хот

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхэд чиглэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийж, хүрсэн төвшнийг төлөвлөсөн зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, удаашралтай хэрэгжиж байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлэхэд явцын хяналт-шинжилгээний зорилго оршино.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ, ДҮГНЭЛТ

Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан ажиллав.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.1-т заасан арга зүйгээр явцын хяналт шинжилгээг Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн хэрэгжилтэд хийсэн.

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд 05 сарын байдлаар явцын хяналт шинжилгээ хийхэд 48 зорилтын 200 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Зорилтын дундаж 74%, арга хэмжээний дундаж 78,4 хувьтай, зорилт арга хэмжээний дундаж хувь 76,2 хувьтай байгаа нь “Эрчимжүүлэх шаардлагатай” байгааг харуулж байна.

Үүнийг бодлогын чиглэлээр нь товчоогоор харуулбал:

Агуулга	Зорилго	Үнэлгээ	Зорилт	Үнэлгээ	Арга хэмжээний тоо	Үнэлгээ	ХБ	0
НЭГ.КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО	1	100	1	100%	6	100%	1	
<b>ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>		43%	19	86,7%	84	81%	19	5
2.1. Эрүүл мэнд	1	50%	5	100%	21	87,2%	5	1
2.2. Биеийн тамир, спорт	1	30%	1	ХБ	7	100%	2	
2.3. Боловсрол	1	ХБ	3	100%	21	77,3%	4	1
2.4. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	1	ХБ	7	50,7%	21	61,7%	4	2
2.5 Үндэсний бахархал, өв соёл	1	100%	3	96,3%	14	78,8%	4	1
<b>ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>		ХБ	11	69%	49	71,4%	17	
3.1 Санхүү, төсвийн зохицуулалт	1	100%	3	66,7%	8	92,1%	1	
3.2 Уул уурхай, хүнд үйлдвэр			1	ХБ	5	50%	4	
3.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр	1	40%	4	66,7%	22	62,8%	8	
3.4 Аялал жуулчлал			1	30%	9	48,6%	2	
3.5 Эрчим хүч			1	100%	2	75%		
3.6 Тээвэр, логистик			1	ХБ	3	100%	2	
<b>ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>		0	9	93,7%	35	86,3%	6	
4.1 Цахим Монгол-төрийн шуурхай үйлчилгээ			1	100%	6	85,2%		
4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба	1	90%	3	95%	9	77,2%	1	
4.3 Хүний эрхийг дээдэлсэн амар тайван, аюулгүй нийгэм	1	0	3	80%	12	89,1%	1	
4.4 Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого			1	100%	4	80%	1	

4.5 Батлан хамгаалах			1	ХБ	4	100%	3	
<b>ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>								
5.1 Ногоон хөгжил		53%	6	64,4%	17	76,5%	4	
<b>ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>								
6.1 Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил	1	ХБ	2	30%	9	55,6%		
Нийт		49%	48	74%	200	78,4%	47	5

### Удаашралтай хэрэгжиж буй арга хэмжээ

Арга хэмжээ: Хот хоорондын зам дагуух сумдын болон алслагдсан бүс нутгийн эмнэлгүүдэд яаралтай тусламжийн цэг байгуулах

Арга хэмжээ: Сайнцагаан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, сумдад шинээр сургуулийн барилга барих

Арга хэмжээ: “Бүрдийн уянга” хүүхдийн зусланд дээвэр, халуун ус, ариун цэврийн шинэ байгууламж, сагсан бөмбөг, гар бөмбөг, тоглоомын талбайг стандартын дагуу тохижуулах

Арга хэмжээ: Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх

Арга хэмжээ: Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилгын ажлыг үргэлжлүүлэх

Арга хэмжээ: “Дундговь үйлдвэрлэл” арга хэмжээг хэрэгжүүлж орон нутгийн онцлогтой брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх хоршоодыг сум бүрд байгуулах

Арга хэмжээ: Төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд шинэ дэвшилтэд техник, технологи /шахмал түлшний үйлдвэр/ нэвтрүүлэх аж ахуйн нэгжийг дэмжих

Арга хэмжээ: Булаг шанд, усыг түшиглэн хур тунадас, цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах

Арга хэмжээ: Сайнцагаан, Дэрэн, Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах

### **Цаашид авч хэрэгжүүлэх санал зөвлөмж**

1. Зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой бичих
2. Хугацаа болоогүй байгаа болон 50 хувиас доош хэрэгжилттэй байгаа тасарч болзошгүй буюу 0 хувьтай байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлж ажиллах талаар харьяа агентлагууддаа чиглэл өгч, хяналт тавих

3. Дараагийн тайланг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдөд танилцуулах тул тайлангийн чанарт анхаарах, нотлох баримтыг цуглуулж хавсаргах
4. ЗДҮАХ-ын 2022 оны хэрэгжилтийг ЗГХЭГ-аас дүгнээд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, тайлагнахдаа анхаарах

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС